



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/541

Номгон

Г Хяналт шалгалт хийх ажлын хэсэг Г
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 /а/, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхонгор аймгийн хэмжээнд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 оноос хойш шинээр баригдсан, одоо баригдаж байгаа барилга байгууламжуудад явцын хяналт хийх, ашиглалтын хугацаа дуусаагүй барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ажиллагаанд дүгнэлт хийх, гүйцэтгэлийн хэрэгжилтийг хянах, илэрсэн зөрчил, дутагдалд хариуцлага тооцож ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Хишигбаатар - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: Д.Алтангэрэл – Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Н.Бямбадорж – Мэргэжлийн хяналтын газрын дарга

Т.Норовринчин - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

С.Хүрэлхуяг – Аймгийн ерөнхий архитектор

Д.Магвансүрэн - Мэргэжлийн хяналтын газрын Тээвэр, авто зам, өргөх механизмын хяналтын улсын ахлах байцаагч

Ч.Сарайдамба – Мэргэжлийн хяналтын газрын Барилга техникийн хяналтын улсын байцаагч

М.Мөнхбат – Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүч (Харилцаа холбоо)-ний хяналтын улсын байцаагч

Ц.Урангоо - Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын ахлах байцаагч

2.

Ц.Уянга - Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч


Л.Батбаяр – Барилгын материалын лабораторийн шинжээч

Ц.Энхтөр – Боловсрол, соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Тухайн сумдын Засаг дарга нар

2. Хяналт шалгалтыг 2021 оны 09 дүгээр сарын 25-ны дотор зохион байгуулж гарсан үр дүнг Засаг даргын зөвлөлд тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг ахлагч (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН